



# ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 91

Улиастай

Аймгийн 2023 оны хөгжлийн  
жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд  
үнэлэлт, дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь.

1. Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.46 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Болдбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Н.ТАМИР





**ЗАВХАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 89

Улиастай

**Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх  
таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн  
явцад үнэлэлт, дүгнэлт өгөх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь.

1. “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн явцыг 67.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсүгэй.

2. “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (Г.Өнөрбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Болдбаатар)-д даалгасугай.



810903121



**ЗАВХАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 90

Улиастай

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэхь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь.

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт 83.8 хувийн биелэлттэйг үндэслэн “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнахыг аймгийн Засаг дарга (Г.Өнөрбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Болдбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Н.ТАМИР





**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 02

Улиастай

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт, Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр ханган, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хугацаанд нь чанартай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл.

Аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2021 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.7.1, 7.7.2, 7.7.3-т заасны дагуу Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг 67.0 хувийн биелэлттэй, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт 83.8 хувийн

биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”, Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.46 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

**Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад бодлогын зорилт, арга хэмжээний хүрэх түвшинг бодитой тодорхойлоогүй, хэрэгжилтэд тохируулан зорилтот түвшинг томъёолсон, суурь болон хүрэх түвшинг тогтоосон боловч журмын 6.2.1 дэх заалтаар үнэлгээг тооцоогүй, бүх үнэлгээг 6.2.2 дахь заалтаар үнэлсэн, биелэлтийг хоосон орхисон, санхүүжилтийн эх үүсвэр болон зарцуулалтыг тайлагнаагүй, нэг арга хэмжээний биелэлтийг хэд хэдэн газар давхар тайлагнасан, үг үсэг, утга найруулгын алдаатай, бодлого хариуцсан мэргэжилтэн болон хэлтсийн дарга зорилт, арга хэмжээний биелэлтийг нэг бүрчлэн хянаж нягтлан боловсруулалт хийгээгүй, хэт товчилсон, тодорхой бус байдлаар тайлагнах зэрэг нийтлэг алдаанууд давтагдсаар байна.

Иймд: Дээр дурдсан алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх, тайлангийн чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

**Төлөвлөлтийн хувьд:**

- Дунд хугацааны буюу Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, онцлогтой уялдуулан төлөвлөх. /Бүх хэлтэс/
- Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтыг жил бүрийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах. /Бүх хэлтэс/
- Аймгийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн нэгжтэй хамтран ажиллаж, салбарын болон нийгэм эдийн засгийн статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн эрэмбийн дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх. /Бүх хэлтэс/
- Тендер зарлахаас зайлсхийх зорилгоор мөнгөн дүнг багасгаж, хэт олон жижиг арга хэмжээ төлөвлөхгүй байх. /ХБТХОХ/
- Тооцоо судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын тоо хэмжээгүй арга хэмжээг төлөвлөхгүй байх. /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч болон удирдах албан тушаалтнууд бодлогын хэлтэс, мэргэжлийн байгууллагын судалгаа, тооцоололгүй арга хэмжээг шууд тусгадаг/

**Тайлагналтын хувьд:**

- Зорилтод түвшинд туссан арга хэмжээг тайлагнахдаа тоон болон чанарын үзүүлэлтийг суурь түвшинтэй харьцуулан дүгнэлт хийж, үр дүнг тооцон ойлгомжтой товч, тодорхой бичихэд анхаарах. /Бүх хэлтэс/

- Хэлтэс хоорондын болон салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, мэдээлэл солилцох, боловсруулалт хийх. Харъяа байгууллагаас ирүүлсэн мэдээ тайланд боловсруулалт хийж, нягтлан дүгнэж тайлагнах, цахимд оруулах. /Бүх хэлтэс/

- Төрийн мэдээллийн сүлжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) мэдээллийн цахим санд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу суурь болон хүрэх түвшин, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, гарсан үр дүнг бодитой, иж бүрэн тайлагнаж хэвших. /Бүх хэлтэс/

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БЯМБАДОРЖ

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ТУЯА

